



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 218,222,635.00 (хоёр зуун арван найман сая хоёр зуун хорин хоёр мянга зургаан зуун гучин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-ын баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ (Э.Энхтөр)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



החלטת הוועדה
למקצועות החינוך
ב-1997

... (החלטת הוועדה)

החלטת הוועדה ... (החלטת הוועדה)

... (החלטת הוועדה)

... (החלטת הוועדה)

... (החלטת הוועדה)

החלטת הוועדה ... (החלטת הוועדה)

... (החלטת הוועדה)

... (החלטת הוועדה)

... (החלטת הוועדה)



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А.У. дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

№	Эд хогшлын нэр	Хэмжээ	Тоо ширхэг	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Шилжүүлэн авах байгууллага
1	Цахилгаан автобусны цэцэглэгч төхөөрөмж	ком	1	2024.08.19	218,222,635.00	218,222,635.00	"Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ
Нийт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн дүн						218,222,635.00	